

Сангийн сайдын 2023 оны 12
дугаар сарын 25-ны өдрийн А/260
дугаар тушаалын хавсралт

ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын нэр: *Улаанбаатар хотын төв байрнууд болон
нэгжүүдийн дохиолол хамгаалалт,
суурилуулалтын үйлчилгээ үзүүлэх*

Тендер шалгаруулалтын
дугаар: *ТБ/20240103211/01/01*

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Тендерийн цар хүрээ

1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон үйлчилгээ (цаашид “үйлчилгээ” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.

1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.

1.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгтэд заана.

2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг

2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.

3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж

3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

4. Худалдан авах ажиллагааны цахим систем

4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.

5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх

5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.

5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20¹, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.

6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага

6.1. Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.

6.2. Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.

6.3. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.

6.4. Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер

ирүүлнэ.

6.5. Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.

6.6. Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

6.7. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага

7.1. Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

7.2. Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

7.3. Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

7.4. ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.

7.5. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

Б.АГУУЛГА

8. Тендер шалгаруулалтын баримт бичиг

8.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;

V Бүлэг. Тендерийн жишиг маягт;

VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

8.2. Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер бэлтгэнэ.

9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах

9.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.

9.2. Тодруулга авах хүсэлтийг өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.

9.3. Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

9.4. Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.

9.5. Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 11-д заасныг мөрдөнө.

10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт

10.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

10.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцоно.

10.3. ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.

11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах

11.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

11.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.

11.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл

12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх үйлчилгээ авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3. Хэрэв ТШЗ-ны 12.2-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

12.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

13. Тендерийн иж бүрдэл

13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн үйлчилгээ үзүүлэх техникийн болон үнийн санал байна.

13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.2.1. ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр

төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3. ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4. оролцогч ТШЗ-ны 16-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.2.5. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.2.6. санал болгож буй үйлчилгээ ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.2.7. ТШЗ-ны 21-д заасан үйлчилгээ үзүүлэх төсөв;

13.2.8. ТШЗ-ны 21.5-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

13.2.9. Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

14. Тендерийн жишиг маягтууд

14.1. Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.

15. Хувилбарт санал

15.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг тендерийн хамт ирүүлж болно.

16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг

16.1. Оролцогчийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадлана. Үүнд:

16.1.1. ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1.

16.1.2. Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн өгөгдлийн хүснэгтэд заана.

16.2. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.2.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

16.2.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

16.2.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

16.3. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.1, 16.2.2-т заасан баримт бичгээс

бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

16.4. Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.

17. Чадавхын болон туршлагын шаардлага

17.1. Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.

17.2. Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.

17.3. Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.

17.4. Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

17.5. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт

18.1. Хуулийн 16.5-д зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна.

18.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.

18.3. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

18.4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт

19.1. Хуулийн 17.4-т зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.

19.2. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.

19.3. Үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана.

19.4. ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

20. Санал болгож буй үйлчилгээ шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг

20.1. Санал болгож буй үйлчилгээ нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.

20.2. III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.

20.3. Үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт

21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

21.2. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

21.3. Үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг “тендерийн үнэ” гэж үзнэ.

21.4. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

21.5. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

22. Тендерийн валют

22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

23. Тендер хүчинтэй байх хугацаа

23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.

23.1. Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.

23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

24. Тендерийн баталгаа

24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.

24.2. Хуулийн 14.6-д зааснаар дараах тохиолдолд тендерийн баталгааг хуульд заасан хувь, хэмжээгээр улсын орлого болгоно. Үүнд:

24.2.1. ТШЗ-ны 23-т заасан тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө өөрийн тендерээс бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн татгалзсан;

24.2.2. гэрээ байгуулах эрх авсан оролцогч гэрээ байгуулах, эсхүл гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй;

24.2.3. Захиалагчийн шийдвэртэй холбогдуулан Сангийн яаманд гаргасан гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.

24.3. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрд ирүүлнэ.

24.4. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

25. Тендер баталгаажуулах, илгээх

25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн 07-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь тус баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа

26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр

өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

- 27. Тендерийн талаар тодруулга авах** 27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.
- 28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх** 28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулгад үндэслэн хянан үзнэ.
- 29. Тендерийг үнэлэх** 29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйл, Сангийн сайдын “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ын дагуу үнэлж, харьцуулна.
- 30. Арифметик алдааг залруулах** 30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.
30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.
- 31. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт** 31.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
- 32. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох** 32.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход дараах дарааллыг баримтална:
32.1.1. ТШЗ-ны 21.1-д зааснаар санал болгосон тендерийн үнийг тогтоох;
32.1.2. ТШЗ-ны 21.3-д заасны дагуу санал болгосон үнийн хөнгөлөлт тооцох;
32.1.3. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу тендерийн үнэд хийсэн арифметик алдааг залруулах;
32.1.4. ТШЗ-ны 29.1.1, 29.1.2, 29.1.3-т заасан үнийг шаардлагатай бол ТШЗ-ны 22.1-д заасан валютад хөрвүүлэх;
32.1.6. ТШЗ-ны 31.1-д заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж тооцох.
32.2. ТШЗ-ны 1.2-т заасны дагуу хоёр ба түүнээс дээш багцтай тендер шалгаруулалтад хэд хэдэн багцад хамтад нь хамгийн бага харьцуулах үнэ санал болгосон тендерийг тодорхойлох, түүнд санал болгосон үнийн хөнгөлөлтийг тооцохдоо дараах аргачлалыг баримтална:
32.2.1. багц тус бүрийн хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгох;
32.2.2. хоёр ба түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлэхээр санал болгосон тендерийн үнээс уг үнийн хөнгөлөлтийг тендер илгээх маягтад тодорхойлсон аргачлалын дагуу тооцсоны дараа шаардлагатай бол түүний харьцуулах үнийг дахин тодорхойлно. Ийнхүү тодорхойлохдоо хоёр ба түүнээс дээш багцад хамгийн бага харьцуулах үнэтэй тендер

ирүүлсэн этгээд нь ТШЗ-ны 34-д зааснаар дахин магадлахад шаардлага хангаж байхыг шаардана;

32.2.3. дээрх үнэлгээг хийсний дараа тендерийн харьцуулах үнэд үндэслэн захиалагч гэрээ байгуулах эрхийг нэг багцад, хэд хэдэн багцад, эсхүл бүх багцад олгох хувилбаруудыг тооцож, гэрээний үнийн нийлбэр нь хамгийн бага байх хувилбарыг сонгох.

32.3. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг хянан үзэж, үнэлнэ.

32.4. ТШЗ-ны 32.3-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.

33. Тендерийг эрэмбэлэх

33.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална.

34. Оролцогчийн чадавхыг дахин магадлах

34.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга хэмжээний мэдээлэлтэй давхацсан тохиолдолд дахин магадална.

34.2. ТШЗ-ны 34.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18.1-д заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 19.1-д заасан техникийн чадавх, туршлага, гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.

34.3. Оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

35. Мэдэгдэл хүргүүлэх

35.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэрийг хуулийн 24.1-д зааснаар ажлын 15 өдрийн дотор гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.

36. Гүйцэтгэлийн баталгаа

36.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.

36.2. Гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.

37. Урьдчилгаа төлбөр

37.1. Гэрээг хэрэгжүүлж эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгохгүй.

38. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах

38.1. Захиалагч VI бүлгийн гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.

38.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх

гэрээний нөхцөлийг баримтална.

38.3. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

38.4. Захиалагч хуулийн 30.4-т зааснаар ажлын 10 өдрийн дотор гэрээг баталгаажуулаагүй бол гэрээ байгуулах шийдвэрт заасан нөхцөлөөр гэрээ байгуулсанд тооцогдоно.

**39. Тендер
гомдол**

шалгаруулалтын 39.1. Хууль болон Сангийн сайдын баталсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын дагуу гомдлыг хянан шийдвэрлэнэ.

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

| | |
|---------------------------------------|--|
| ТШЗ-ны холбогдох заалт | А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ |
| ТШЗ 1.1 | Захиалагч: ТӨРИЙН БАНК ХК |
| ТШЗ 1.1 | Тендер шалгаруулалтын нэр: Улаанбаатар хотын төв байрнууд болон нэгжүүдийн дохиолол хамгаалалт, суурилуулалтын үйлчилгээ үзүүлэх |
| ТШЗ 1.1 | Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: ТБ/20240103211/01/01 |
| ТШЗ 1.2 | Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцтай <ul style="list-style-type: none"> • Багц №1 Баруун бүс • Багц №2 Зүүн бүс • Багц №3 Урд бүс • Багц №4 Хойд бүс |
| ТШЗ 1.3 | Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: Үгүй |
| ТШЗ 2.1 | Санхүүжилтийн эх үүсвэр нь: Өөрийн хөрөнгө |
| ТШЗ 2.1 | Нийт төсөвт өртөг: 232,980,000 (Хоёр зуун гучин хоёр сая есөн зуун наян мянган төгрөг) <ul style="list-style-type: none"> • Багц №1 Баруун бүс – 54,240,000 /тавин дөрвөн сая хоёр зуун дөчин мянган төгрөг • Багц №2 Зүүн бүс – 62,160,000 /Жаран хоёр сая нэг зуун жаран мянган/ төгрөг • Багц №3 Урд бүс – 56,820,000 /тавин зургаан сая найман зуун хорин мянган/ төгрөг • Багц №4 Хойд бүс – 59,760,000 /Тавин есөн сая долоон зуун жаран мянган/ төгрөг |
| Б.АГУУЛГА | |
| ТШЗ 9.1 | Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хүлээн авагчийн нэр: Худалдан авалт хариуцсан мэргэжилтэн С.Энхтунгалаг Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Холбоочдын гудамж, Төрийн банкны төв 2-р байр, Худалдан авалтын үйл ажиллагааны хэлтэс, 2-р давхар, 202 тоот өрөө Утасны дугаар: 7505-1881 /4310/ Цахим шуудангийн хаяг: procurement@statebank.mn |
| ТШЗ 10.1 | Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: Үгүй |

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

| ТШЗ 12.1 | Тендер шалгаруулалтын хэл: <i>Монгол хэл.</i> | | | | | | | | | | | | | | | | | | |
|------------|--|---|-----------------------------|-------------|-----------------------------------|-------------|-----------------------------------|---|--------------------------------------|---|------|---|---------------|---|--------------------------------------|---|------|---|---------------|
| ТШЗ 15.1 | Хувилбарт санал ирүүлэхийг: <i>Зөвшөөрөхгүй</i> | | | | | | | | | | | | | | | | | | |
| ТШЗ 16.1.2 | <p>Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: <i>Шаардана ТБОНӨХБАҮХАТ хуулийн 7.1.2-д заасны дагуу дараах лавлагаануудыг цахим системээр шалгана. Үүнд:</i></p> <ul style="list-style-type: none"> • <i>Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу өр төлбөр төлүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа эсэх тодорхойлолт;</i> • <i>Татвар болон Нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өртэй эсэх тодорхойлолт;</i> | | | | | | | | | | | | | | | | | | |
| ТШЗ 18.1 | <p>Санхүүгийн чадавхын шаардлага: <i>“Шаардана”</i></p> <ul style="list-style-type: none"> - <i>Борлуулалтын орлогын хэмжээ: 2022, 2023 он тус бүрийн борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан нийт төсөвт өртөг /232,980,000 төгрөг/-ийн 100 хувиас багагүй байх.</i> - <i>Ашигтай ажилласан жилийн тоо: 2022, 2023 он тус бүр.</i> | | | | | | | | | | | | | | | | | | |
| ТШЗ 18.2 | <p>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:</p> <ul style="list-style-type: none"> - <i>Үнэлгээнд харгалзах санхүүгийн тайлангийн хугацаа 2022, 2023 он. /Цахим санхүүгийн тайлан “E-BALANCE” системд дээрх онуудын жилийн эцсийн санхүүгийн тайлан шивэгдэж баталгаажсан байх шаардлагатай бөгөөд Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан шаардлагатай мэдээллүүдийг шалгана/</i> - <i>Тендерт оролцогч нь тендер шалгаруулалт зарласнаас хойшхи өдрийн байдлаар харилцагч банкны хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар тодорхойлолт эсхүл Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан /Монголбанкнаас зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компани/ этгээдийн лавлагааг цахим системээр авч ирүүлнэ.</i> | | | | | | | | | | | | | | | | | | |
| ТШЗ 19.1 | <p>Техникийн чадавх болон туршлагын шаардлага: <i>Шаардана</i></p> <p>Үйлчилгээ үзүүлэх хүний нөөц: <i>Шаардана</i></p> <p><i>Доорх шаардлагууд нь зөвхөн нэг багцад хамаарах бөгөөд бусад багцад санал болгосон боловсон хүчин давхцахгүй байх шаардлагатай. Үүнд:</i></p> <table border="1" data-bbox="448 1659 1469 2056"> <thead> <tr> <th data-bbox="448 1659 517 1783">Д/д</th> <th data-bbox="517 1659 735 1783">Шаардлагатай боловсон хүчин</th> <th data-bbox="735 1659 1023 1783">Боловсрол</th> <th data-bbox="1023 1659 1166 1783">Үндсэн ажилтан эсэх</th> <th data-bbox="1166 1659 1262 1783">Ажилтны тоо</th> <th data-bbox="1262 1659 1469 1783">Нийгмийн даатгалын шимтгэл төлөлт</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="448 1783 517 1939">1</td> <td data-bbox="517 1783 735 1939">Шуурхай бүлгийн хамгаалалтын ажилтан</td> <td data-bbox="735 1783 1023 1939">“Гэрээт харуул хамгаалалтын алба хаагч бэлтгэх сургалт”-ын гэрчилгээний хуулбар</td> <td data-bbox="1023 1783 1166 1939">Тийм</td> <td data-bbox="1166 1783 1262 1939">1</td> <td data-bbox="1262 1783 1469 1939">Сүүлийн 3 сар</td> </tr> <tr> <td data-bbox="448 1939 517 2056">2</td> <td data-bbox="517 1939 735 2056">Шуурхай бүлгийн хамгаалалтын ажилтан</td> <td data-bbox="735 1939 1023 2056">-</td> <td data-bbox="1023 1939 1166 2056">Тийм</td> <td data-bbox="1166 1939 1262 2056">1</td> <td data-bbox="1262 1939 1469 2056">Сүүлийн 3 сар</td> </tr> </tbody> </table> | Д/д | Шаардлагатай боловсон хүчин | Боловсрол | Үндсэн ажилтан эсэх | Ажилтны тоо | Нийгмийн даатгалын шимтгэл төлөлт | 1 | Шуурхай бүлгийн хамгаалалтын ажилтан | “Гэрээт харуул хамгаалалтын алба хаагч бэлтгэх сургалт”-ын гэрчилгээний хуулбар | Тийм | 1 | Сүүлийн 3 сар | 2 | Шуурхай бүлгийн хамгаалалтын ажилтан | - | Тийм | 1 | Сүүлийн 3 сар |
| Д/д | Шаардлагатай боловсон хүчин | Боловсрол | Үндсэн ажилтан эсэх | Ажилтны тоо | Нийгмийн даатгалын шимтгэл төлөлт | | | | | | | | | | | | | | |
| 1 | Шуурхай бүлгийн хамгаалалтын ажилтан | “Гэрээт харуул хамгаалалтын алба хаагч бэлтгэх сургалт”-ын гэрчилгээний хуулбар | Тийм | 1 | Сүүлийн 3 сар | | | | | | | | | | | | | | |
| 2 | Шуурхай бүлгийн хамгаалалтын ажилтан | - | Тийм | 1 | Сүүлийн 3 сар | | | | | | | | | | | | | | |

| | | | | | |
|---|----------------------------|---|------|---|---------------|
| 3 | Мэргэжлийн инженер | Мэргэжлийн бакалавр /эсхүл түүнээс дээш/ дипломын хуулбар | Тийм | 1 | Сүүлийн 3 сар |
| 4 | Техникч | Мэргэжлийн сургалтанд хамрагдсан сертификатын хуулбар | Тийм | 1 | Сүүлийн 3 сар |
| 5 | 24 цагийн байнгын оператор | - | Тийм | 1 | Сүүлийн 3 сар |

- **Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан шалгах тул ажилтнуудын регистрийн дугаарыг ирүүлнэ.**

- **Санал болгож буй ажилтан нь сүүлийн 3 сар тухайн байгууллагад нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх шаардлагатай.**

Үйлчилгээ үзүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл:
Шаардана

Багц тус бүр дээр шуурхай бүлгийн 1 автомашинтай байх

- **Тээврийн хэрэгслийн гэрчилгээ**
- **Тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрэл дохио тавьж хэрэглэх зөвшөөрөл.**
- **Түрээсээр ашигладаг бол түрээсийн гэрээ болон нотлох баримт ирүүлэх**
- **Pima брендийн бүх төрлийн дохиолол хамгаалалтын системийн тоног төхөөрөмжүүдийг дэмжин ажиллах чадвартай программ хангамж болон пульттай байх /зураг, танилцуулга ирүүлэх/**

Харуул хамгаалалтын ажилтан нь дараах тусгай хэрэгслээр хангагдсан байх бөгөөд тусгай хэрэгслийн зураг, танилцуулгыг ирүүлнэ. Үүнд:

- **Гав,**
- **резинэн эсхүл цахилгаан бороохой,**
- **нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр /аль нэг нь/,**
- **резинэн эсхүл хуванцар сумтай буу.**

/Дээрх шаардлагууд нь зөвхөн нэг багцад хамаарах бөгөөд бусад багцад санал болгосон техник хэрэгсэл давхцахгүй байх шаардлагатай/

Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлага: **Шаардана**

2022, 2023 он тус бүр багц тус бүрийн хувьд батлагдсан төсөвт өртгийн 100 хувиас багагүй үнийн дүнтэй дохиолол хамгаалалт, суурилуулалтын үйлчилгээ үзүүлсэн байна.

- **Үйлчилгээ үзүүлсэн гэрээний хуулбар ирүүлнэ.**
- **Үйлчилгээ хүлээлцсэн акт /гэрээ дүгнэсэн акт/ эсхүл захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ.**

Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага:
Шаардахгүй

Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад шаардлага: **Шаардахгүй**

| | |
|-------------------------------|--|
| ТШЗ 19.2 | <p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:</p> <ol style="list-style-type: none"> 1. <i>Байгууллагын тухай танилцуулга ирүүлнэ.</i> 2. <i>Үйлчилгээний үнийн задаргаа ирүүлнэ.</i> 3. <i>Тендерт шалгарсан тохиолдолд нэгжүүдийн дохиолол, суурилуулалт, харуул хамгаалалтын үйлчилгээг гэрээний үнэ, хугацаанд, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгэхийг баталсан албан бичиг ирүүлнэ.</i> 4. <i>“Гэрээт харуул хамгаалалтын тухай” хуулийн 13, 20 дугаар зүйлүүдийг бүрэн хангасан байхыг баталсан албан бичиг ирүүлнэ.</i> 5. <i>Pima брендийн эсхүл түүнтэй дүйцэхүйц бүх төрлийн дохиолол хамгаалалтын системийн тоног төхөөрөмжүүдийг дэмжин ажиллах чадвартай програм хангамж болон Sentry нулттай байхыг баталсан албан бичиг ирүүлнэ.</i> 6. <i>Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний дагуу төлөх төлбөрийг зөвхөн Төрийн банкны харилцах дансаар дамжуулан хийхийг зөвшөөрсөн албан бичиг ирүүлнэ.</i> |
| ТШЗ 19.3 | <p>Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: <i>Шаардана</i></p> <p><i>Харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ болон хавсралтын эхээс хийсэн хуулбар ирүүлнэ.</i></p> <p><i>/Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа нь үйлчилгээ үзүүлэх хугацаанд хүчинтэй байх/</i></p> |
| ТШЗ 21.4 | <p>Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: <i>Тохируулахгүй тогтмол байна</i></p> |
| ТШЗ 24.1 | <p>Тендерийн баталгааны дүн: <i>1,694,900 /Хоёр сая нэг зуун ерэн зургаан мянга гурван зуун далан төгрөг/</i></p> <ul style="list-style-type: none"> • <i>Багц №1 Баруун бүс - 271,200 төгрөг</i> • <i>Багц №2 Зүүн бүс – 310,800 төгрөг</i> • <i>Багц №3 Урд бүс – 284,100 төгрөг</i> • <i>Багц №4 Хойд бүс – 298,800 төгрөг</i> |
| Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ | |
| ТШЗ 25.5 | <p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт: <i>ТБОНӨХБАҮХАТ хуулийн 22.6-д заасан баримт бичиг.</i></p> |
| ТШЗ 26.1 | <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: <i>2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр</i></p> <p>Цаг: <i>10 цаг 00 минут</i></p> |
| ТШЗ 26.2 | <p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.</p> <p>Огноо: <i>2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр</i></p> <p>Цаг: <i>10 цаг 10 минут</i></p> <p>Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: <i>Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Холбоочдын гудамж, Төрийн банкны төв 2-р байр, 2-р давхар, 202 тоот өрөө</i></p> |

| | |
|---|---|
| Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ | |
| ТШЗ 31.1 | Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: <i>Үгүй.</i> |
| Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ | |
| ТШЗ 36.1 | Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: <i>Тийм</i> <i>Гүйцэтгэлийн баталгааг зөвхөн Төрийн банкаар гаргаж ирүүлнэ.</i> |

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Төрийн банкны Улаанбаатар хотын Дохиолол хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх тендерийг 4 бүсэд хуваасан 4 багцаар шалгаруулна.

Үйлчилгээ үзүүлэгчийн талаас шаардагдах доорх шалгуур үзүүлэлт нь багц тус бүрт тавигдана:

- Гэрээт харуул хамгаалалтын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх.
- Дохиолол хамгаалалтын үйлчилгээг 2-оос доошгүй жил үзүүлж байсан туршлагатай байх.
- Богино долгионы радио станцтай, 24 цагийн байнгын оператортай, бүрэн тоноглогдсон 1-ээс доошгүй шуурхай бүлгийн автомашинтай байх. Шуурхай бүлэг нь 2-оос доошгүй хамгаалалтын ажилтантай байна.
- Мэргэжлийн инженер-1, Техникч-1 буюу түүнээс дээш ажилтантай байх /Мэргэжлийн инженер нь мэргэжлийн диплом ирүүлэх/
- Шуурхай бүлгийн хамгаалалтын ажилтнуудын 30-аас доошгүй хувь нь “Гэрээт харуул хамгаалалтын ажилтан бэлтгэх сургалт”-д хамрагдаж гэрчилгээ авсан байх.
- “Гэрээт харуул хамгаалалтын тухай” хуулийн доорхи 13 болон 20 дугаар зүйлийг хангасан байх. Үүнд:

13 дугаар зүйл. Харуул хамгаалалтын байгууллагын үүрэг

13.1. Харуул хамгаалалтын байгууллага дараахь үүрэгтэй:

13.1.1. Харуул хамгаалалтын алба хаагчийг дүрэмт хувцас, ялгах тэмдэг, бусад хэрэгслээр хангах, хууль зүйн болон холбогдох сургалтад хамруулах;

13.1.2. Тусгай хэрэгсэл хэрэглэх зааврыг байгууллагынхаа хэмжээнд дагаж мөрдүүлэх;

13.1.3. Харуул хамгаалалтын алба хаагчаар 20 нас хүрсэн, эрүүл мэнд, бие бялдар, ёс зүйн шаардлага хангасан, зохих боловсрол, ажлын туршлагатай, холбогдох сургалтад хамрагдсан, ял шийтгэлгүй хүнийг ажиллуулах;

13.1.4. Үйл ажиллагаатай нь холбогдуулан цагдаагийн байгууллагаас тавьсан шаардлагыг биелүүлэх;

13.1.5. Хууль тогтоомж, гэрээнд заасан бусад үүрэг.

20 дугаар зүйл. Нэг бүрийн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх

20.1. Харуул хамгаалалтын алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг эсэргүүцэнийг хүч хэрэглэхгүйгээр таслан зогсоох боломжгүй бол харуул хамгаалалтын алба хаагч мэх, дараахь нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэж болно:

20.1.1. гав;

20.1.2. хүлэг;

20.1.3. резинэн ба цахилгаан бороохой;

20.1.4. нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр;

20.1.5. резинэн ба хуванцар сумтай буу.

- Pima брендийн бүх төрлийн дохиолол хамгаалалтын системийн тоног төхөөрөмжүүдийг дэмжин ажиллах чадвартай програм хангамж болон пульттай байх.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА, ХЯНАЛТ

1. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

1.1. Гэрээний хугацаа:

- *Багц №1 Баруун бүс-2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс 2026 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийг дуустал,*
- *Багц №2 Зүүн бүс - 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс 2026 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийг дуустал,*
- *Багц №3 Урд бүс – 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал,*
- *Багц №4 Хойд бүс - 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал.*

1.2 Гэрээний дагуу дохиолол хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх хугацаа нь 24 цаг байна.

2. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

2.1 Дохиоллын системийн баталгаат хугацааны болон зохих төлбөртэй үйлчилгээг үзүүлэх. Баталгаат хугацаанд гадны нөлөөгүй зөвхөн техникийн гэмтлийг засварлах, мэдрэгчүүдийн тохируулгын ажлыг үнэ төлбөргүй хийх.

2.2 Объект халдлагад өртсөн тохиолдолд гэмт үйлдлийг таслан зогсоох, бусад хамгаалагчдад туслалцаа үзүүлэх, аврах үүрэгтэй.

2.3 Үйлчлүүлэгч талын итгэмжлэгдсэн төлөөлөгч болон харуул хамгаалалтын ажилтанд мэргэжлийн зааварчилгаа, зөвлөгөө өгөх, Үйлчлүүлэгч талын итгэмжлэгдсэн төлөөлөгч ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд дохиоллын код, нууц үгийг өөрчлөх санал тавих, мэдээллийг шуурхай солилцох үүрэгтэй.

2.4 Хамгаалагч тал нь хамгаалалтын техникийн болон шуурхай үйлчилгээний дор дурдсан шаардлагыг бүрэн хангана. Үүнд:

2.4.1 Дохиоллын систем нь хамгаалж байгаа объектыг бүрэн хамрахаар тооцож техник хэрэгслийг тоноглох, байрлалыг сонгож зонын хуваарилалтайгаар, план зургийг Аюулгүй байдал хариуцсан нэгжид хүргүүлж баталгаажуулна.

2.4.2 Дохиоллын техник хэрэгслийг бүрэн тоноглож, туршиж, Үйлчлүүлэгчийн ашиглалтад актын дагуу хүлээлгэж өгөх:

2.4.3 Дохиоллын техник хэрэгслийн тасралтгүй, хэвийн ажиллагааг хангаж тогтмол хяналт шалгалт хийж, үйлчлүүлэгч талд тайлан актыг улирал тутамд ирүүлж байх:

2.4.4 Үйлчлүүлэгчийн объектод засвар үйлчилгээ хийгдэх, нүүх бүрд шинэчилсэн дохиолол хамгаалалтын план зургийг зонын хуваарилалтайгаар Аюулгүй байдал хариуцсан нэгжид хүргүүлэх:

2.4.5 Үйлчлүүлэгчийн объектод засвар үйлчилгээ хийгдэх, нүүх, шинэ байранд орох үед дохиоллын тоног төхөөрөмжийг салгаж авах болон шинээр суурилуулах ажлыг Үйлчлүүлэгчийн батлагдсан төсөвт багтаан хийж гүйцэтгэх;

2.5 Үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн зардлаар хариуцлагын даатгал, хамгаалалтын алба хаагчийн амь нас болон эрүүл мэндийн даатгалд даатгуулах бөгөөд Үйлчлүүлэгчийн хүсэлтээр даатгуулсан тухай болон даатгалын төлбөр хийсэн талаарх нотлох баримтыг энэхүү гэрээг баталгаажуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлнэ.

2.6 Хамгаалж байгаа эд хөрөнгө, объект, түүний онцлог, хамгаалалтыг зохион байгуулах талаар Үйлчлүүлэгч талын байгууллагын нууцад хамрахаас бусад шаардлагатай мэдээлэл авах, харилцан мэдээлэл солилцох:

2.7 Хамгаалж байгаа эд хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулахтай холбогдсон санал Үйлчлүүлэгчид тавих.

2.8 Гэрээний заагдсан объектуудыг дохиоллын хамгаалалтад авч холбогдох инженер техникийн ажилтныг томилон төхөөрөмжийн хэвийн ажиллагаанд хяналт тавих.

2.9 Үйлчилгээ үзүүлэгч нь дохиоллын тоног төхөөрөмжийн ажиллагаанд хяналт тавих, хэвийн ажиллагааг хангаагүй бөгөөд тоног төхөөрөмж ажиллаагүйн улмаас Үйлчлүүлэгч талд учирсан хохирлыг бүрэн төлж барагдуулна. (Жич: Үйлчлүүлэгч талын ажилтны буруутай үйлдлээс болж дохиолол хамгаалалтын системд учирсан гэмтлээс үүдэн гарсан хохирлыг үйлчлэгч тал хариуцахгүй.)

2.10 Үйлчилгээ үзүүлэгч гэрээний үүргээ зөрчсөний улмаас Үйлчлүүлэгчид хохирсон хохирлыг энэхүү гэрээний 6.4-д зааснаас бусад тохиолдолд бүрэн хариуцах:

2.11 Үйлчилгээ үзүүлэгч дараах байдлаар гэрээг зөрчсөнийг ноцтой зөрчсөн гэж үзнэ.

2.11.1 Үйлчилгээ үзүүлэгч түүний хамгаалалтын алба хаагч гэрээний үүргээ зөрчсөн ба зөрчлийг арилгуулах талаар мэдэгдэл хүргүүлсэн хугацаанд зөрчлийг арилгаагүй буюу давтсан:

2.11.2 Объектоос түгшүүрийн болон аюулгүй товчлуурын дуудлага үйлчилгээ үзүүлэгчид ирэхэд гэрээний Үйлчилгээ үзүүлэх хуваарьт заасан хугацаанд багтаан очиж объектыг хамгаалалтад авч, зөрчлийг таслан зогсоогоогүй:

2.11.3 Үйлчилгээ үзүүлэгч дохиоллын тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаанд хяналт тавих үүргээ хэрэгжүүлээгүйн улмаас дохиолол ажиллаагүй, эсвэл түүний улмаас Үйлчлүүлэгчид хохирол учирсан бол.

3. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1 Хаалт, нээлт хийх код авах итгэмжлэгдсэн төлөөлөгчийг албан ёсоор томилж, гэрээний нөхцөлийг танилцуулах

3.2 Нууц код, нууц үг эзэмшигч итгэмжлэгдсэн төлөөлөгч өөрчлөгдсөн, эсвэл бусад этгээдэд мэдэгдсэн тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч талд энэ тухайгаа нэн даруй мэдэгдэж, шинээр нууц код, түлхүүр үг авах, мэдээллийг шуурхай солилцох:

3.3 Дохиолол хамгаалалтын тоног төхөөрөмжийг Үйлчилгээ үзүүлэгч талын өгсөн заавар, журмын дагуу ашиглах:

3.4 Объектод засвар хийх, эд хогшил, тавилга, хаалт, лангуу, сурталчилгааны самбар гэх мэтийн байрлалыг өөрчлөхөд дохиоллын системийн мэдрэгчүүдийг халхлахаар бол энэ тухай Үйлчилгээ үзүүлэгч талд 24 цагаас доошгүй хугацааны өмнө урьдчилан мэдэгдэж, авах арга хэмжээг авхуулах:

3.5 Объектын хана, таазыг өөрчлөх, нураах, өргөтгөл хийх бол Үйлчилгээ үзүүлэгч талд урьдчилан мэдэгдэж, авах арга хэмжээг харилцан тохиролцох:

3.6 Үйлчилгээ үзүүлэгч талаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зогсоох дохиолол хамгааллын үйл ажиллагааг сайжруулах талаар тавьсан санал, хууль ёсны шаардлагыг тухай бүр хүлээн авч, ажлын 5 хоногийн дотор хариуг өгөх: Үйлчлүүлэгч хариу өгөөгүй арга хэмжээ аваагүйн улмаас учирсан хохирлыг үйлчлэгч тал хариуцахгүй байж болно.

3.7 Аюул дамжуулах ширээний нууц товчлуур, биедээ авч яваа зөөврийн товчлуурыг шаардлагагүй үед санаатай болон санамсаргүй дарсан тохиолдолд хамгаалалтын төвийн 7010-4050 дугаарын утсанд нэн даруй мэдэгдэх:

3.8 Хамгаалуулж байгаа объектын дотор мөнгөн тэмдэгт, үнэт цаас, үнэт эдлэл хадгалах тохиолдолд зориулалтын хүндрүүлэгчтэй төмөр сейфт хадгалж байх:

3.9 Хамгаалуулж байгаа объектын хана тааз, хаалга, цонх, дээврийн нээлхий нь бат бөх хийгдсэн, түгжээ, цоожтой байх шаардлагыг хангасан байх:

3.10 Объектыг хамгаалахад шаардлагатай цахилгааны болон телефон угасны төлбөрөө хугацаанд нь төлсөн байх,

3.11 Итгэмжлэгдсэн төлөөлөгч ямар нэгэн шалтгаанаар ажилдаа ирэхгүй болон хаалт, нээлт хийх боломжгүй болсон тохиолдолд бусад итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс хэн нэгийг ирүүлэх;

3.12 Үйлчилгээ үзүүлж буй байгууллагаас сургалт авах болон хамтран сургалт зохион байгуулах.

4. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үүрэг

4.1 Үйлчилгээ үзүүлэгч талд санал хүсэлт, гомдол гаргах, шийдвэрлүүлэх:

4.2 Нууц кодыг задруулахгүй байх, хэрэв нууц код алдагдсан гэж үзвэл Үйлчилгээ үзүүлэгч талд яаралтай мэдэгдэх, шинэ код авах:

4.3 Дохиоллын тоног төхөөрөмж ашиглах зааварчилгааг Үйлчилгээ үзүүлэгч талаас авах, зааварчилгааны дагуу ашиглах:

4.4 Өөрийн хаяг, утас болон шаардлагатай мэдээллийг Үйлчилгээ үзүүлэгч талд үнэн зөв өгч, өөрчлөлт гарсан даруйд мэдэгдэж байх:

4.5 Ажлын цаг дуусаж Объектыг хамгаалалтад өгөхийн өмнө цахилгаан хэрэгсэл, ус, дулааны шугам, хаалга цонхны бэхжилтийг шалгасны дараа код өгөх:

4.6 Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь дохиоллын нууц код хийж Үйлчилгээ үзүүлэгч талын операторт мэдэгдэж объектыг бүрэн хамгаалалтад авагдсан тухай мэдээлэл авсны дараа явах:

4.7 Итгэмжлэгдсэн төлөөлөгч ажилдаа ирэхгүй болон хаалт, нээлт хийх боломжгүй болсон тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч талд урьдчилан мэдэгдэх:

4.8 Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь дараах тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч талын хүсэлт, шаардлагаар объектод биеэр хүрэлцэн ирж объектын нээж өгч хамтран ажиллана. Үүнд:

4.8.1 Үйлчилгээ үзүүлэгч Объект дохиоллын хамгаалалтад авагдаагүй талаар мэдэгдсэн үед:

4.8.2 Дохиоллын системд техникийн гэмтэл саатал гарсан, цахилгаан тасарснаас дохиоллын системийн нөөц батарей суусан:

4.8.3 Объектод гэмт халдлага гарсан үед:

4.8.4 Объектоос түгшүүрийн мэдээ дахин дахин ирж, шуурхай бүлэг дотогш орж шалгах шаардлагатай гэж үзсэн нөхцөлд:

5. Тайлан, мэдээ, шуурхай бүлэгт тавигдах шаардлага

5.1 Үйлчилгээ үзүүлэгч тал хамгаалалтын объект нэг бүрээр хаалт, нээлт хийсэн хугацаа хамгаалалт хэрэгжүүлэх үед гарсан зөрчил, халдлагыг таслан зогсоож шаардлагатай ямар арга хэмжээг хэрхэн авсан, энэ тухай Үйлчлүүлэгчийн эрх бүхий албан тушаалтанд мэдэгдсэн тухай болон Үйлчлүүлэгч талаас тухайн сард хэрхэн хамтарч ажилласан, өөрийн талаас авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар дэлгэрэнгүй мэдээ, тайланг дараа сарын эхний ажлын өдөр Үйлчлүүлэгч талд бичгээр ирүүлэх ба эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан байна.

5.2 Дохиоллын хамгаалалтад байгаа объектоос түгшүүрийн болон аюулгүй товчлуурын дуудлага хүлээн авсны дараа шуурхай бүлэг тухайн объект дээр Үйлчилгээ үзүүлэх хуваарьт заасан хугацаанд очсон байна.

5.3 Дуудлага хүлээн авсан хугацааг тогтоохдоо Үйлчилгээ үзүүлэгч талын төв пультны мэдээллийг үндэс болгоно.

5.4 Шуурхай бүлэг нь дохиоллын хамгаалалтад байгаа объектын дохиоллын систем залгаатай үед хоногт 2-с доошгүй удаагийн давтамжтайгаар эргэж шалгана. Үүнд:

5.4.1 Үйлчилгээ үзүүлэгч талын оператор нь объектын хаах цагт объектын хаалгаж хүлээн авч, нээх цагт объектын нээлгэж хяналт тавьж ажиллана.

5.4.2 Хэрэв объект хаах цагтаа хаахгүй бол тэр тухай утсаар лавлаж хаах цагт нь объектын хамгаалалтад авч объект хамгаалалтад орсон тухай итгэмжлэгдсэн төлөөлөгчид мэдэгдэнэ.

5.4.3 Оператор нэмэлт мэдээлэл хүлээн авсан тохиолдолд нэн даруй Шуурхай бүлэгт мэдэгдэн шаардлагатай мэдээллээр хангаж ажиллана.

5.4.4 Объект хаасан цагаас нээх цаг хүртэл Гүйцэтгэгчийн хамгаалалтад байгаа учраас итгэмжлэгдсэн төлөөлөгч тухайн байгууллагын ажилтан нар урьдчилан мэдэгдэхгүйгээр объектод нэвтрэхийг хориглоно.

5.4.5 Итгэмжлэгдсэн төлөөлөгч объектын хамгаалалтад өгөөгүй явсан бол энэ тухай өөрт нь яаралтай мэдэгдэн, объектын хамгаалалтад өгөхийг шаардаж ирүүлэн хамгаалалтад авна. Хэрэв итгэмжлэгдсэн төлөөлөгч хамгаалалтад өгөөгүй явснаас гэмт халдлагад өртвөл үйлчилгээ үзүүлэгч тал хариуцлага хүлээхгүй болно.

5.4.6 Итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй холбоо барих боломжгүй тохиолдолд тус банкны удирдлага, холбогдох албан тушаалтанд мэдэгдэнэ.

5.4.7 Удаан хугацаагаар цахилгаан тасрах үед дохиоллын системийн батарейг солих шаардлагатай бол итгэмжлэгдсэн төлөөлөгчид мэдэгдэн батарейг сольж хамгаалалтыг үргэлжлүүлэн хийнэ.

5.4.8 Объект халдлагад өртсөн тохиолдолд хэргийн газрыг хамгаалж, үйлчлүүлэгч талын удирдлага, итгэмжлэгдсэн төлөөлөгч, ерөнхий жижүүрийг иртэл объектын хамгаална.

5.4.9 Бэлэн байдал, түргэн шуурхай байдлыг байнга ханган ажиллана.

6. Хяналт, Хариуцлага

6.1 Үйлчлүүлэгч нь гэрээнд заасан хамгаалалтын хугацаанд гарсан гэрээний үүргийн зөрчил, ажлын доголдлыг арилгах тухай мэдэгдлийг Үйлчилгээ үзүүлэгчид өгнө.

6.1.1 Зөрчил доголдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр Үйлчилгээ үзүүлэгч уг зөрчил доголдлыг Үйлчлүүлэгчийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар шуурхай арилгана.

6.1.2 Хэрэв Үйлчлүүлэгч нь Үйлчлүүлэгчийн мэдэгдэлд заасан хугацаанд гаргасан алдаа дутагдлыг арилгаагүй бол 1 объектын 1 сарын хөлсний 30хувиар тооцож торгууль ногдуулах бөгөөд Үйлчилгээ үзүүлэгч уг торгууль, учирсан хохирлыг Үйлчлүүлэгчид төлөх ба Үйлчилгээ үзүүлэгчид төлөх гэрээний төлбөрөөс суутган тооцно.

6.1.3 Үйлчилгээ үзүүлэгчийн дохиолол хамгаалалтад авсан объектын тоног төхөөрөмж гэмтсэн тохиолдолд дохиолол хамгаалалтын системийн гэмтэл тодорхойлсон акт үйлдэж Үйлчлүүлэгч талын Аюулгүй байдал хариуцсан нэгжид эх хувиар болон мэйл хаягаар ирүүлж байх.

6.1.4 Үйлчилгээ үзүүлэгчийн дохиолол хамгаалалтад байгаа объектын тоног төхөөрөмж эвдэрсэн тохиолдолд Үйлчлүүлэгч тал тухайн тоног төхөөрөмжийг солих асуудлыг шийдтэл өөрийн хөрөнгөөр түр орлуулан байрлуулж дохиолол хамгаалалтын системийн гэмтсэн тоног төхөөрөмжийн оронд түр байрлуулах хөрөнгийн акт үйлдэж Аюулгүй байдлын газар руу хүргүүлж байх.

6.1.5 Үйлчилгээ үзүүлэгч тал түр байрлуулах тоног төхөөрөмж дээр сери дугаар хийсэн байх.

6.2 Дохиоллын хамгаалалтын хугацаанд гэмт халдлага болж, эд материалын хохирол учирсан тохиолдолд 2 талаас тус бүр 2-с доошгүй тэнцүү тоотой хүнийг томилж магадлах комиссыг бүрдүүлэх ба шалтгаан нөхцөлийг тогтоосны үндсэн дээр учирсан хохирлын хэрхэн хариуцах асуудлыг шийдвэрлэнэ. /Магадлах комисс нь цаг хугацааны маргаантай асуудал гарсан тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч талын төв пультны мэдээллийг үндэс болгоно.

6.3 Үйлчилгээ үзүүлэгчийн шуурхай бүлэг энэ гэрээний 5 дугаар бүлгийн 5.2-т заасан Үйлчилгээ үзүүлэх хуваарьт заасан хугацаанд объектын хамгаалалтад аваагүй нь төв пультны мэдээгээр

нотлогдсон бөгөөд гэмт халдлагын таслан зогсоогоогүйн улмаас Үйлчлүүлэгчийн эд хөрөнгө, материалд хохирол учирсан бөгөөд гэрээний 6.4-т заасан шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор хохирлыг Үйлчлүүлэгчид бүрэн төлж барагдуулна.

6.4 Үйлчилгээ үзүүлэгч тал дараах тохиолдолд учирсан хохирол, хариуцлагаас чөлөөлөгдөнө. Үүнд:

6.4.1 Байгалийн Гэнэтийн болон давтагдашгүй хүчин зүйлийн улмаас эд материалын хохирол учирсан;

6.4.2 Халдлагын ул мөрийг үйлчлүүлэгч тал санаатай болон санамсаргүйгээр арилгасан;

6.4.3 Гал түймрийн аюулаас учирсан хохирол;

6.4.4 Гаднын этгээд объект дотор үлдсэнээс болж гэмт халдлага үйлдэгдсэн бол;

6.4.5 Объектын бэхжилт шаардлага хангагдаагүй;

6.4.6 Үйлчлэгч гэрээний үүргээ биелүүлсэн.

ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ХУВААРЬ

Үйлчилгээ үзүүлэгч талын шуурхай бүлэг нь Улаанбаатар хотын объектуудад дараах хугацаанд багтаан хүрэлцэн очих. Үүнд:

Өвөл: Өдөр 15-18 минутад

Шөнө 7-9 минутад

Зун: Өдөр 12-15 минутад

Шөнө 5-7 минутад

НЭГЖҮҮДИЙН БҮСЧЛЭЛИЙН ХУВААРЬ /Багц тус бүрээр/

| Дүүрэг | № | Нэгжийн нэр | Бүсчлэл |
|---------------------------|----|---|---------|
| БАГЦ №1 БАРУУН БҮС | | | |
| БГД | 1 | 1024 - "БАРУУН ХҮРЭЭ" ТООЦООНЫ ТӨВ | Баруун |
| БГД | 2 | 1028 - "ӨРГӨӨ" ТООЦООНЫ ТӨВ | Баруун |
| БГД | 3 | 1032 - "10-Р ХОРООЛОЛ" ТООЦООНЫ ТӨВ | Баруун |
| БГД | 4 | 1041 - "БИЧИЛ" ТООЦООНЫ ТӨВ | Баруун |
| БГД | 5 | 1045 - "БАЯНГОЛ" ТООЦООНЫ ТӨВ | Баруун |
| БГД | 6 | 1051 - "МОДНЫ 2" ТООЦООНЫ ТӨВ | Баруун |
| БГД | 7 | 1067 - "3-ХОРООЛОЛ" ТООЦООНЫ ТӨВ | Баруун |
| БГД | 8 | 1098 - "БАРС" ТООЦООНЫ ТӨВ | Баруун |
| БГД | 9 | 3407 -"БАРУУН 4 ЗАМ " ЗЭЭЛИЙН ТӨВ | Баруун |
| БГД | 10 | 3840 - "БАЯНГОЛ ДҮҮРЭГ" САЛБАР | Баруун |
| БГД | 11 | 3851 - "АЛТАЙ ХОТХОН" ТООЦООНЫ ТӨВ | Баруун |
| СХД | 12 | 1011 - "ХАРХОРИН" ТООЦООНЫ ТӨВ | Баруун |
| СХД | 13 | 1035 - "ӨНӨР" ТООЦООНЫ ТӨВ | Баруун |
| СХД | 14 | 1037 - "СОНГИНО ХАЙРХАН" ТООЦООНЫ ТӨВ | Баруун |
| СХД | 15 | 1043 - "БАЯНХОШУУ" ТООЦООНЫ ТӨВ | Баруун |
| СХД | 16 | 1048 - "ТАВАН ШАР" ТООЦООНЫ ТӨВ | Баруун |
| СХД | 17 | 1066 - "ДРАГОН" ТООЦООНЫ ТӨВ | Баруун |
| СХД | 18 | 3422-"СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ САЛБАР" | Баруун |
| СХД | 19 | 3703-"ОРБИТ" ТООЦООНЫ ТӨВ | Баруун |
| СХД | 20 | 3852-"ТОЛГОЙТ" ТООЦООНЫ ТӨВ | Баруун |
| СХД | 21 | ШИНЭ ТООЦООНЫ ТӨВ | Баруун |
| СХД | 22 | ТАВАН ШАР АРХИВЫН БАЙР | Баруун |
| БАГЦ №2 ЗҮҮН БҮС | | | |
| БЗД | 1 | 1031 - "САНСАР" ТООЦООНЫ ТӨВ | Зүүн |
| БЗД | 2 | 1038 - "ЦАЙЗ" ТООЦООНЫ ТӨВ | Зүүн |
| БЗД | 3 | 1039 - "15-Р ХОРООЛОЛ" ТООЦООНЫ ТӨВ | Зүүн |
| БЗД | 4 | 1052 - "ЧУЛУУН-ОВОО" ТООЦООНЫ ТӨВ | Зүүн |
| БЗД | 5 | 1063 - "НАРАНГУУЛ" ТООЦООНЫ ТӨВ | Зүүн |
| БЗД | 6 | 1078 - "ДА ХҮРЭЭ" ТООЦООНЫ ТӨВ | Зүүн |
| БЗД | 7 | 1092 - "ОФИЦЕР" ТООЦООНЫ ТӨВ | Зүүн |
| БЗД | 8 | 3126-"УЛИАСТАЙ" ТООЦООНЫ ТӨВ | Зүүн |
| БЗД | 9 | 3424-" ГАЧУУРТ" ТООЦООНЫ ТӨВ | Зүүн |
| БЗД | 10 | 3469 - "БАЯНМОНГОЛ" ТООЦООНЫ ТӨВ | Зүүн |
| БЗД | 11 | 3700-"ЗҮҮН 4 ЗАМ" ЗЭЭЛИЙН ТӨВ | Зүүн |
| БЗД | 12 | 3702 - "БАЯНЗҮРХ" АВТО ТЭЭВЭР ТООЦООНЫ КАСС | Зүүн |
| БЗД | 13 | 3810 - "БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ" САЛБАР | Зүүн |
| НаД | 14 | 1081 - "ХОНХОР" ТООЦООНЫ ТӨВ | Зүүн |
| НаД | 15 | 3005 - "НАЛАЙХ БАГАХАНГАЙ" ТООЦООНЫ ТӨВ | Зүүн |
| НаД | 16 | 3007 - "НАЛАЙХ ӨНДӨРТӨЛГӨЙ" ТООЦООНЫ ТӨВ | Зүүн |
| НаД | 17 | 3125 - "НАЛАЙХ ДҮҮРЭГ" САЛБАР | Зүүн |
| НаД | 18 | 3129 - "МУСТАНГ" ТООЦООНЫ ТӨВ | Зүүн |
| НаД | 19 | 3130 - "ДЭНЖ" ТООЦООНЫ ТӨВ | Зүүн |
| НаД | 20 | 3131 - "ГОРОДОК" ТООЦООНЫ ТӨВ | Зүүн |
| БЗД | 21 | 15-Р ХОРООЛОЛ АГУУЛАХ | Зүүн |
| БЗД | 22 | 15-Р ХОРООЛОЛ АРХИВЫН БАЙР | Зүүн |
| БЗД | 23 | БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН АГУУЛАХ | Зүүн |
| БЗД | 24 | САНСАРЫН АРХИВЫН БАЙР | Зүүн |

| БАГЦ №3 УРД БҮС | | | |
|-------------------------|----|---|------|
| БГД | 1 | 1089 - "ХОТЫН ГААЛЬ" ТООЦООНЫ КАСС | Урд |
| БЗД | 2 | 1062 - "13-Р ХОРООЛОЛ" ТООЦООНЫ ТӨВ | Урд |
| БЗД | 3 | 3406 -"БӨХИЙН ӨРГӨӨ" ТООЦООНЫ ТӨВ | Урд |
| ЧД | 4 | 3400 - "ТӨВ" САЛБАР | Урд |
| ХУД | 5 | 1027 - "120 МЯНГАТ" ТООЦООНЫ ТӨВ | Урд |
| ХУД | 6 | 1036 - "БУЯНТ-УХАА" ТООЦООНЫ ТӨВ | Урд |
| ХУД | 7 | 1040 - "ЯАРМАГ" ТООЦООНЫ ТӨВ | Урд |
| ХУД | 8 | 1054 - "ДУНД ГОЛ" ТООЦООНЫ ТӨВ | Урд |
| ХУД | 9 | 1074 - "ОРГИЛ" ТООЦООНЫ ТӨВ | Урд |
| ХУД | 10 | 1075 - "ЦЭНГЭЛДЭХ" ТООЦООНЫ ТӨВ | Урд |
| ХУД | 11 | 3418 -"ГЭГЭЭНТЭН" ЗЭЭЛИЙН ТӨВ | Урд |
| ХУД | 12 | 3489 - "ЗАМ ТЭЭВРИЙН ЯАМ" ТООЦООНЫ ТӨВ | Урд |
| ХУД | 13 | 3701-"ХАН-УУЛ НИЙГМИЙН ДААТГАЛ" ТООЦООНЫ КАСС | Урд |
| ХУД | 14 | 3704 -"ЭНКАНТО" ТООЦООНЫ ТӨВ | Урд |
| ХУД | 15 | 3850-"ХАН-УУЛ ДҮҮРЭГ САЛБАР" | Урд |
| ХУД | 16 | 3854 - "ШИНЭ ЯАРМАГ" ТООЦООНЫ ТӨВ | Урд |
| СБД | 17 | 1022 - "АРСЛАНТАЙ ГҮҮР" САЛБАР | Урд |
| СБД | 18 | 1023 - "ТАВИН МЯНГАТ" ТООЦООНЫ ТӨВ | Урд |
| СБД | 19 | 1033 - "ТЭЭВРИЙН ТОВЧОО" ТООЦООНЫ ТӨВ | Урд |
| СБД | 20 | 3401-"СҮХБААТАР ДҮҮРЭГ" САЛБАР | Урд |
| СБД | 21 | 3413 - "ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ" САЛБАР | Урд |
| СБД | 22 | 50 МЯНГАТ ОФИСИЙН БАЙР | Урд |
| БАГЦ №4 ХОЙД БҮС | | | |
| ЧД | 1 | 1021 - "ЗАНАБААЗАР" САЛБАР | Хойд |
| ЧД | 2 | 1026 - "17 - ИЙН БУУДАЛ" ТООЦООНЫ ТӨВ | Хойд |
| ЧД | 3 | 1029 - "БАГА ТОЙРУУ" ТООЦООНЫ ТӨВ | Хойд |
| ЧД | 4 | 1044 - "ЯЛАЛТ" ТООЦООНЫ ТӨВ | Хойд |
| ЧД | 5 | 1050 - "ЧИНГЭЛТЭЙ" ТООЦООНЫ ТӨВ | Хойд |
| ЧД | 6 | 1069 - "УРТ ЦАГААН" ТООЦООНЫ ТӨВ | Хойд |
| ЧД | 7 | 1090- "АРД" ЗЭЭЛИЙН ТӨВ | Хойд |
| ЧД | 8 | 3432 - "ХАРАА" ТООЦООНЫ ТӨВ | Хойд |
| ЧД | 9 | 3465 - "МӨНГӨН ЗАВЪЯА" ТООЦООНЫ ТӨВ | Хойд |
| ЧД | 10 | 3800 - "ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ" САЛБАР | Хойд |
| ЧД | 11 | 3853 -"НАРЛАГ ДЭНЖ" ТООЦООНЫ ТӨВ | Хойд |
| СБД | 12 | 1001 - "ЗАНАБААЗАР" ЗЭЭЛИЙН ТӨВ | Хойд |
| СБД | 13 | 1009 - "11-Р ХОРООЛОЛ" ТООЦООНЫ ТӨВ | Хойд |
| СБД | 14 | 1049 - "ГУРВАН ЯАМ" ТООЦООНЫ КАСС | Хойд |
| СБД | 15 | 1084 - "ДАМБА" ТООЦООНЫ ТӨВ | Хойд |
| СБД | 16 | 1088 - "МУИС" ТООЦООНЫ ТӨВ | Хойд |
| СБД | 17 | 1095-" ХОЙМОР" ТООЦООНЫ ТӨВ | Хойд |
| СБД | 18 | 3412 - "МЕТРОМОЛЛ" ТООЦООНЫ ТӨВ | Хойд |
| СБД | 19 | 3431 - "ШУТИС" ТООЦООНЫ ТӨВ | Хойд |
| СБД | 20 | 3830-"ЗУУН АЙЛ " ТООЦООНЫ ТӨВ | Хойд |
| ЧД | 21 | ТӨВ 1-Р БАЙР | Хойд |
| ЧД | 22 | ТӨВ 2-Р БАЙР | Хойд |
| ЧД | 23 | БИЗНЕС ИНКУБАТОР ТӨВ | Хойд |
| ЧД | 24 | ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН АГУУЛАХ | Хойд |

IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 32.1-д үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт ашиглахаар заасан бол захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.

Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн саналаас гадна энэ хэсэгт заасан нэг буюу хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.

Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд харгалзахгүй.

1. *Үйлчилгээ дуусгах хугацаа: **Ашиглахгүй***
2. *Үйлчилгээний гэрээний гүйцэтгэлийн дараах үйлчилгээг захиалагчийн заасан газар үзүүлэх боломж: **Ашиглахгүй***
3. *Байгаль орчинд нөлөөлөх байдал: **Ашиглахгүй***
4. *Хуульд нийцсэн бусад шалгуур үзүүлэлт: **Ашиглахгүй***

У БҮЛЭГ.ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ

Маягт 1.Тендер илгээх маягт

[огноо]

[Захиалагч байгууллагын нэр]-д

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтад [үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу үйлчилгээ үзүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний гүншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:
 - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
 - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
 - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй.
 - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт [*“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих*]. [*Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих*].
5. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш [*ажлын 30 ба түүнээс дээш хоногийн тоо*] хоногийн хугацаанд хүчинтэй байна.¹
6. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 6 дугаар зүйл, 13.4 болон 17.1-д заасныг зөрчсөн, эсхүл тендерт хуурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг тендерийг илт худал мэдээлэл бүхий тендер гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон үйлчилгээ нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,

¹ Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол “5. Тендер нь тендерийн баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.” гэж сольж бичнэ үү.

*эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,
албан тушаал, гарын үсэг,
байгууллагын тамга, тэмдэг]:*
Хаяг:

Маягт 2. Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн гэрээний мэдээлэл

| Гэрээний нэр | Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас | Төсөвт өртөг | Хугацаа /эхэлсэн, дууссан/ |
|--------------|---|--------------|----------------------------|
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

Маягт 3.Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

| | |
|---|---------------------------------|
| Оролцогчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө]. | |
| 1. | Захиалагчийн нэр |
| 2. | Гэрээний нэр |
| 3. | Гэрээний дугаар |
| 4. | Гэрээ байгуулсан огноо |
| 5. | Гэрээ дуусгавар болсон огноо |
| 6. | Гэрээний дүн |
| 7. | Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил |
| Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч | |

Маягт 4.Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

| Гэрээний нэр | Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас | Төсөвт өртөг | Гэрээ эхэлсэн хугацаа | Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр | Дуусах хугацаа |
|--------------|---|--------------|-----------------------|---|----------------|
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

Маягт 5. Үйлчилгээг үзүүлэх ажлын хөтөлбөр болон аргачлалын талаарх танилцуулга

Техникийн тодорхойлолтод тусгагдсан ажлын даалгаврыг гүйцэтгэх аргачлалын талаарх танилцуулга болон хэрэв ажлын даалгаврын талаар гаргах санал, зөвлөмж ирүүлнэ.

Маягт 6. Үйлчилгээ үзүүлэх хуваарь

Техникийн тодорхойлолтод тусгагдсан ажлын даалгаврын дагуу үзүүлэх үйлчилгээг гүйцэтгэх хуваарийг боловсруулж ирүүлнэ.

Маягт 7. Хүний нөөцийн мэдээлэл

| Албан тушаал | Ажилтны нэр | Боловсрол, мэргэжлийн ур чадвар | Нийт ажлын туршлага, жилээр | Тухайн албан тушаалд ажилласан туршлага, жилээр |
|---------------------|--------------------|--|--|--|
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

Маягт 10. Санал болгож буй ажилтны жишиг намтар (cv)

Санал болгож буй албан тушаал: _____

Овог, нэр: _____

Мэргэжил: _____

Төрсөн он, сар, өдөр: _____

Тухайн байгууллагад ажилласан жил: _____ Иргэншил: _____

Мэргэжлийн холбооны гишүүнчлэл: _____

Хариуцах ажил: _____

Ур чадварын:

[Хариуцах ажлын чиглэлээр туршилагажсан, сургалтад хамрагдсан байдлыг товч харуулна. Өмнө гүйцэтгэж байсан ижил төрлийн зөвлөх үйлчилгээнд хариуцаж байсан ажил, хугацаа, байршилыг зааж харуулах. Эдгээр мэдээллийг хагас хуудсанд багтааж бичнэ.]

Боловсрол:

[Мэргэжилтний их, дээд сургууль, коллеж болон бусад эзэмшсэн мэргэжлийн боловсролын байдал, сургуулийн нэрс, оролцсон/дүүргэсэн хугацаа болон хамгаалсан эрдмийн зэргийн хамт нэгтгэж харуулах. Эдгээр мэдээллийг хуудасны дөрөвний нэгт багтааж бичнэ.]

Ажилласан туршлага:

[Өнөөгийн байдлаас эхлэн эсрэг дарааллаар ажилласан туршилагыг бич. Сургууль төгссөнөөс хойш ажилласан бүх албан тушаалын нэр, ажил эрхэлсэн хугацаа, ажил олгогч байгууллага, байршил зэргийг бичнэ. Сүүлийн 10 жилийн туршилагын хувьд гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ болон шаардлагатай бол харилцагчийн тодорхойлолтыг хавсаргана. Эдгээр мэдээллийг бичгийн 2 хуудсанд багтаан бичнэ.]

Хэлний мэдлэг:

[Эзэмшсэн хэлний мэдлэгийн түвшинг ярих, унших, бичих тус бүрт онц, сайн, дунд эсхүл муу гэж тодорхойлно.]

Батламж:

Дээрх мэдээлэл нь миний мэдлэг, чадвар, туршлагыг үнэн зөв харуулсан болохыг үүгээр баталж байна.

Мэргэжилтний овог, нэр, гарын үсэг: _____ Огноо: _____

Эрх бүхий этгээдийн овог, нэр, гарын үсэг: _____ Огноо: _____

Маягт 11. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл

| Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт | Хүчин чадал | Тоо ширхэг | <i>["Өөрийн эзэмшил" эсхүл "түрээс" аль нэгийг бичих]</i> |
|--|--------------------|-------------------|--|
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

Маягт 12. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

| | | Нууцалсан баримт бичиг, мэдээлэл | Хүний эмзэг мэдээлэлд хамаарах хууль зүйн үндэслэл |
|----|--|---|---|
| 1. | | | |
| 2. | | | |
| 3. | | | |
| 4. | | | |
| 5. | | | |

VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

- 1.1. Энэхүү гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл дор дурдсан утгыг агуулна:
 - 1.1.1. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.2. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Гүйцэтгэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
 - 1.1.3. “Гүйцэтгэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.4. “Гүйцэтгэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Гүйцэтгэгчээс томилогдсон этгээдийг;
 - 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Гүйцэтгэгчийг хамтад нь нэрлэснийг;
 - 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
 - 1.1.7. “Үйлчилгээ” гэж ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасан ажлыг;
 - 1.1.8. “Ажлын байр” гэж ажил гүйцэтгэж байгаа газрыг;
 - 1.1.9. “Баталгаат хугацаа” гэж гүйцэтгэсэн ажлыг ашиглах явцад ажилд илэрсэн доголдлыг Гүйцэтгэгч хариуцах хугацааг;
 - 1.1.10. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж Захиалагчаас баталгаат хугацаанд илрүүлсэн доголдолтой холбогдуулж Гүйцэтгэгчид шаардлага гаргах хугацааг;
 - 1.1.11. “Тэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио цээр тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

Тайлбар

- 1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:
 - 1.2.1. Ганц тоогоор илэрхийлсэн үг нь олон тоон утгыг, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоон утгыг илэрхийлж болно.
 - 1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.
 - 1.2.3. Зүйл, заалт, үг өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд

тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.

1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.

1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

ХОЁР. ЗАХИАЛАГЧ

Захиалагчийн нийтлэг үүрэг

2.1. Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан хугацаанд үнийг төлнө.

2.2. Захиалагч хууль тогтоомж болон гэрээнд заасан баримт бичиг, зөвшөөрлийг Гүйцэтгэгчид зохих ёсоор гаргаж өгнө.

2.3. Захиалагч нь үйлчилгээ авахтай холбоотой гаргаж өгсөн ажлын даалгавар, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийн алдаатай холбоотой үр дагаврыг хариуцна.

Захиалагчийн төлөөлөгч

2.4. Захиалагчийг төлөөлөн гүйцэтгэгчтэй харилцах, хяналт тавих төлөөлөгчийг Захиалагч томилно.

2.5. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээллийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.

2.6. Захиалагчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

Талбайд нэвтрэх зөвшөөрөл

2.7. Захиалагч нь ажил эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд ажлын талбайд нэвтрэх, үйл ажиллагаа явуулах эрхийг Гүйцэтгэгчид бичгээр олгоно.

2.8. Ажлын талбайд нэвтрэх эрх олгоогүйгээс ажил гүйцэтгэх хугацаа хэтрэх болон түүнтэй холбоотой үүссэн аливаа үр дагаврыг Захиалагч хариуцна.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ

Гүйцэтгэгчийн нийтлэг үүрэг

3.1. Гүйцэтгэгч нь ажлыг техникийн тодорхойлолтод заасан шаардлагад нийцүүлэн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, Захиалагчид хүлээлгэн өгнө.

3.2. Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллах хүч (удирдах ажилтан, инженер, техникийн ажилтан гэх мэт) болон ашиглаж буй тоног төхөөрөмж, машин механизмын дэлгэрэнгүй жагсаалт, мэдээллийг Захиалагчид өгнө.

3.3. Ажил гүйцэтгэхэд шаардагдах материал, техник, тоног төхөөрөмж, машин механизм, сэлбэг хэрэгсэл, баримт бичгүүд, Гүйцэтгэгчийн түр ба байнгын ажлын байранд ажиллах ажилтан болон үйлчилгээг гүйцэтгэгч хариуцна.

3.4. Ажлын явцад шаардлагатай ус, хий, цахилгаан холбооны болон бусад хангамжийг Гүйцэтгэгч хариуцна.

3.5. Гүйцэтгэгч нь нийт ажлын 20 (хорь) хувиас дээш ажлыг Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.

3.6. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй.

- | | |
|--|---|
| Гүйцэтгэгчийн төлөөлөгч | 3.7. Гүйцэтгэгч нь захиалагч, түүний эрх олгосон этгээдийг ажлын талбайд чөлөөтэй нэвтрүүлэх үүрэгтэй. |
| | 3.8. Гүйцэтгэгч нь Захиалагчтай харилцах эрх бүхий этгээдийг томилж, гэрээ баталгаажуулах маягтад заана. |
| | 3.9. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тухайн салбараар мэргэшсэн, дадлага туршлага бүхий хүн байна. |
| | 3.10. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно. |
| Техникийн болон ажлын талбайн өгөгдөл | 3.11. Захиалагч нь үйлчилгээтэй холбоотой нөхцөл байдлын талаарх өөртөө байгаа бүх өгөгдөл мэдээллийг Гүйцэтгэгчид мэдээллийн журмаар ажил эхлэхээс өмнө өгнө. |
| Аюулгүй байдал | 3.12. Гүйцэтгэгч ажлын талбайд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Галын аюулгүй байдлын хууль зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдалд холбогдох бусад хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандарт, норм ба дүрмийг дагаж мөрдүүлнэ. |
| | 3.13. Гүйцэтгэгч нь ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангана. |
| | 3.14. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг байгалийн болон бусад хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаална. |
| | 3.15. Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана. |
| | 3.16. Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой үүссэн аливаа хариуцлагыг бүрэн хариуцна. |
| | 3.17. Гүйцэтгэгч нь ГЕН-ийн 3.19-3.22-т заасан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх аливаа үр дагаврыг бүрэн хариуцна. |
| | 3.18. Ажилд ашигласан эсхүл бий болгосон аюултай, хортой, бохирдсон материал, бодисыг холбогдох хууль тогтоомж, Захиалагчийн шаардлагын дагуу хадгалж, устгана. |

ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА, ЯВЦЫН ТАЙЛАН

- | | |
|-----------------------|--|
| Ажил эхлэх | 4.1. Гүйцэтгэгч нь ГТН-д заасан хугацаанд ажлыг эхлүүлж, ажлын хуваарийн дагуу гүйцэтгэнэ. |
| | 4.2. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө)-ийг ГТН-д заасан хугацаанд захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ. |
| | 4.3. Хөтөлбөрт ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажлыг эхлэхээс дуусах хүртэл ажлын үе шатны хугацааг болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан байна. |
| | 4.4. Хөтөлбөр (төлөвлөгөө)-г өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн төлөөлөгчид мэдэгдэнэ. |
| Хугацаа сунгах | 4.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно: 4.5.1. ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон; |

- 4.5.2. холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт шинээр батлагдсан, өөрчлөгдсөн нь ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр байвал;
- 4.5.3. Захиалагч хугацаандаа төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй;
- 4.5.4. Захиалагч зөвшөөрөл, баримт бичиг гаргуулах хүргүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь ажлын хугацаанд нөлөөлсөн.
- 4.6. Гүйцэтгэгч хугацаа сунгах хүсэлтийг холбогдох нотлох баримтын хамт Захиалагчид ирүүлнэ.
- 4.7. ГЕН-ийн 4.5.1-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Гүйцэтгэгч нотлох үүрэгтэй.
- 4.8. Захиалагч ГЕН-ийн 4.5-д заасан үндэслэлийн аль нэг нь бүрдсэн тохиолдолд Гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.
- Ажлын явцын тайлан** 4.9. Гүйцэтгэгч ажлын явцын тайланг ГТН-д заасан хуваарийн дагуу гаргаж Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 4.10. Явцын тайланд үйл ажиллагаа бүрийн бодит гүйцэтгэлийн хувийг гаргаж, түүнийг төлөвлөсөн хувьтай харьцуулсан харьцуулалт, хийгдээгүй ажил байвал тухайн ажлын талаарх мэдээлэл, хэзээ хийх санал, Захиалагчийн төлөөлөгчийн шаардсан бусад мэдээллийг тусгана.
- 4.11. Гүйцэтгэгч нь ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг ажиллуулж, техник үйлчилгээ хийх, задлах, буцаан угсрах, тохиргоо хийх болон засварлах талаар ашиглалт үйлчилгээний зааварчилгааг Захиалагчид гаргаж өгнө.

ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БА ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- Гэрээний үнэ** 5.1. Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягтад заана.
- 5.2. Гэрээний үнэд хуулийн 11.11-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д тусгана.
- 5.3. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.
- Урьдчилгаа төлбөр** 5.4. Тендер шалгаруулалтын баримт бичигт урьдчилгаа төлбөр олгохоор заасан бөгөөд Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийн хүсэлт гаргасан бол Захиалагч урьдчилгаа төлбөрийг ГТН-д заасан хэмжээгээр олгоно.
- 5.5. Захиалагч нь урьдчилгаа төлбөрийн баталгааг хүлээн авснаас хойш Гүйцэтгэгчид ГТН-д заасан хугацаанд урьдчилгаа төлбөр олгоно.
- Төлбөрийн нөхцөл** 5.6. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг төлнө.
- 5.7. Захиалагч гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.
- 5.8. Гүйцэтгэгчийн хүсэлтээр Захиалагч ажил хүлээлгэн өгөх хугацааг ГЕН-ийн 4.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.
- 5.9. Захиалагчийн төлсөн аливаа төлбөрийг ажил, түүний бүрэлдэхүүний хэсгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх үндэслэл болохгүй.

- 5.10. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.
- 5.11. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутгана.

ЗУРГАА. БАТАЛГАА БА БАТАЛГААТ ХУГАЦАА

- | | |
|--------------------------------------|--|
| Урьдчилгаа төлбөрийн баталгаа | 6.1. ГЕН-ийн 5.4-д заасны дагуу урьдчилгаа төлбөр олгохоор бол ГТН-д заасан хэмжээний урьдчилгаа төлбөрийн баталгааг ГТН-д заасан хугацааны дотор хуульд заасан хэлбэрээр, холбогдох маягтын дагуу ирүүлнэ. |
| Гүйцэтгэлийн баталгаа | 6.2. Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Гүйцэтгэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Гүйцэтгэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ. |
| | 6.3. Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна: <ul style="list-style-type: none"> 6.3.1. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй; 6.3.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй; 6.3.3. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон. |
| | 6.4. Захиалагч Гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулсан нь Гүйцэтгэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй. |
| | 6.5. ГЕН-ийн 4.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна. |
| | 6.6. Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 6.8-д заасан Чанарын баталгаа гаргаснаар Гүйцэтгэлийн баталгааг чөлөөлнө. |
| Чанарын баталгаа | 6.7. Үйлчилгээний чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно. Чанарын баталгаа гаргуулах бол чанарын баталгааны хэмжээг ГТН-д заана. |
| | 6.8. Гүйцэтгэгч Чанарын баталгааг хуулийн 42.5-д заасны дагуу баталгаажуулж болно. |
| | 6.9. ГЕН-ийн 6.9-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно. |
| | 6.10. Баталгаат хугацаанд үйлчилгээнд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө. |
| | 6.11. ГЕН-ийн 8.6-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Гүйцэтгэгчид олгоно. |
| | 6.12. ГЕН-ийн 8.5-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат болон гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ. |

- Баталгаат хугацаа**
- 6.13. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт баталгаат хугацаа тогтоох бөгөөд баталгаат хугацааг ГТН-д заана.
- 6.14. Захиалагч нь баталгаат хугацаанд илэрсэн доголдлыг арилгуулахыг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.

ДОЛОО. ЭРСДЭЛ БА ДААТГАЛ

- Бусдад учруулсан хохирлыг арилгах**
- 7.1. Үйлчилгээ үзүүлэх хугацаанд Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч түүний эрх бүхий этгээдийн аливаа үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас бусдад эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол хохирлыг Гүйцэтгэгч хариуцна.
- 7.2. Захиалагч түүний эрх олгогдсон этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол Гүйцэтгэгч хариуцахгүй.
- Захиалагчийн хүлээх эрсдэл**
- 7.3. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:
- 7.3.1. Үйлчилгээний үр дүнг захиалагчид шилжүүлснээс хойш ажлын үр дүн Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гэмтсэн, устсан;
- 7.3.2. гүйцэтгэсэн үйлчилгээг хүлээлгэн өгөх мэдэгдэл өгсөн боловч захиалагч ажлыг хүлээн авах үүргээ биелүүлээгүйгээс ажил, түүний бүрэлдэхүүн хэсэг гэмтсэн, устсан;
- 7.3.3. Захиалагчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас үйлчилгээ, материал болон тоног төхөөрөмж гэмтсэн, устсан;
- 7.3.4. Захиалагчийн ажлын даалгаврын алдааны улмаас үүссэн аливаа эрсдэл.
- 7.4. Үйлчилгээний доголдлын улмаас захиалагч ажлын үр дүнг хүлээн авахаас татгалзсан бол ажлыг хүлээн авах хүртэлх хугацаанд бий болсон аливаа эрсдэлийг захиалагч хариуцахгүй.
- Даатгал**
- 7.5. Гүйцэтгэгч нь ажлын явцад учирч болзошгүй эрсдэлийг ажил эхлэх өдрөөс дуусах хүртэл хугацаанд ГТН-д заасан даатгалд даатгуулна.
- 7.6. Захиалагч болон гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирч болзошгүй хохирлыг Гүйцэтгэгч даатгуулна.
- 7.7. Гүйцэтгэгч нь даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 7.8. Гүйцэтгэгч даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг ирүүлээгүй бол захиалагч уг даатгалын гэрээг байгуулж, даатгалын хураамжийг Гүйцэтгэгчээс гаргуулна.
- 7.9. Даатгалын нөхцөлийг Захиалагчийн төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно.

НАЙМ. ДОГОЛДОЛ, ДАЛД ДОГОЛДОЛ

- Доголдлыг арилгах**
- илрүүлэх,**
- 8.1. Гүйцэтгэгчээс ирүүлсэн үйлчилгээ, түүний хэсэг нь зөрчил, доголдолгүй байна.
- 8.2. Захиалагчийн төлөөлөгч үйлчилгээний явцад зөрчил, доголдолтой байж болзошгүй аливаа ажилд зөрчил, доголдлыг илрүүлэх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг Гүйцэтгэгчид өгнө.

- 8.3. Захиалагч хүлээж авсан ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт ГТН-д заасан баталгаат хугацааны дотор зөрчил, доголдол илэрвэл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ.
- 8.4. Гүйцэтгэгч Доголдол арилгах тухай мэдэгдлийг хүлээн авмагц доголдол арилгах ажлыг эхлүүлнэ.
- 8.5. Доголдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр Гүйцэтгэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.
- 8.6. Гүйцэтгэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгаж болно.
- 8.7. Захиалагчийн гаргасан зардлыг Гүйцэтгэгч үл маргах журмаар төлнө.
- 8.8. Доголдлыг арилгах явцад ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг Захиалагч ашиглаж чадаагүй бол доголдлыг арилгах хугацаагаар баталгаат хугацаа сунгагдана.
- 8.9. Ажил хүлээн авсан баримт (акт) үйлдсэн ч ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт илэрсэн, далд доголдол, түүний улмаас үүссэн аливаа үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.
- 8.10. Зураг төслийг Захиалагч боловсруулсан бол зураг төсөлтэй холбоотой аливаа асуудал (зураг төслийн үнэн зөв, түүнээс үүссэн ажлын доголдол гэх мэт)-ыг Захиалагч хариуцна.
- 8.11. Гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэсэн Ажлын зураг төсөл, холбогдох баримт бичгүүд, мэдээлэл ба өгөгдлүүдийн үнэн зөвийг хариуцна.

ЕС. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

- Захиалагч гэрээг цуцлах**
 - 9.1. Захиалагч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:
 - 9.1.1. Гүйцэтгэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр үйлчилгээ үзүүлээгүй;
 - 9.1.2. Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацааг тогтоосон боловч үр дүн гараагүй;
 - 9.1.3. Гүйцэтгэгч Гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн бусдад шилжүүлсэн, бусдаар гүйцэтгүүлсэн;
 - 9.1.4. Гүйцэтгэгч нь тендерт оролцохдоо буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгийн гэмт хэрэгт холбогдсон нь шүүх болон холбогдох байгууллагаар тогтоогдсон;
 - 9.1.5. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;
 - 9.1.6. Гүйцэтгэгч нийт ажлын 20 (хорь)-аас дээш хувийг нэг буюу түүнээс дээш туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлсэн;
 - 9.1.7. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон.
 - 9.1.8. Гүйцэтгэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг

- биелүүлээгүй, эсхүл хуулийн этгээдийн хувьд тус нөхцөлийг хангахгүй болсон.
- 9.2. Захиалагч ГЕН-ийн 9.1-д заасан үндэслэлээс гадна хэдийд ч гэрээг цуцалж болно.
- Гүйцэтгэгч гэрээг цуцлах** 9.3. Гүйцэтгэгч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:
- 9.3.1. Захиалагч нь гэрээнд заасан үндсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бөгөөд тогтоосон нэмэлт хугацаанд биелүүлээгүй;
- 9.3.2. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;
- 9.3.3. Захиалагч нь ажлыг түр зогсоосон нь гүйцэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөр бол.
- Гэрээг цуцлах журам** 9.4. Гэрээг цуцлах тал нь нөгөө талдаа үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.
- 9.5. Тогтоосон нэмэлт хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл нэмэлт хугацаа тогтоосон ч үр дүнд хүрэхгүй болох нь илт, ГЕН-ийн 4.8-т зааснаар хугацаа сунгагдсан бол Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.
- 9.6. Нэмэлт хугацаа тогтоох шаардлагагүй, нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэлд хариу ирүүлээгүй эсхүл тогтоосон хугацаанд зөрчлийг арилгаагүй тохиолдолд гэрээг цуцлах тал нь нөгөө талд гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлнэ.
- 9.7. Гүйцэтгэгч ГЕН-ийн 9.6-т заасан мэдэгдлийг хүлээн авсан бол нэн даруй эсхүл мэдэгдэлд заасан хугацаанд ажлын гүйцэтгэсэн хэсгийг хамгаалах, ажлын талбайг цэвэр аюулгүй нөхцөлд үлдээхэд чиглэснээс бусад цаашид гүйцэтгэх бүх ажлаа зогсоож, Гэрээг цуцлах өдөр хүртэл гүйцэтгэсэн ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт холбогдох баримт бичгүүдийг Захиалагчид баримт (акт үйлдэн)-аар хүлээлгэн өгнө.
- Гэрээг цуцалсны дараах төлбөр** 9.8. ГЕН-ийн 9.1-д заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Гүйцэтгэгч гэрээг цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөрийг шаардах эрхтэй.
- 9.9. ГЕН-ийн 9.2-т заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Захиалагч гүйцэтгэгчид дараах төлбөрийг төлнө:
- 9.9.1. Гэрээ цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөр;
- 9.9.2. Ажлын талбайгаас Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг нүүлгэхтэй холбоотой үүссэн зардал;
- 9.9.3. Гэрээг цуцалсантай холбоотойгоор Гүйцэтгэгчээс туслан гүйцэтгэгчид төлөх шаардлагатай болсон аливаа төлбөр;
- 9.9.4. Гүйцэтгэгчээс ажлыг хамгаалах, ажлын талбайг цэвэр, аюулгүй нөхцөлд үлдээхэд зарцуулсан зардал;
- 9.9.5. Гэрээг цуцалсантай шууд холбоотой бусад зардал, учирсан хохирол.

АРАВ. БУСАД ЗААЛТ

Мэдэгдэл

- 10.1. Талуудын мэдэгдэл, зааварчилгаа, мэдээлэл болон бусад харилцаа төлөөлөгчөөр дамжина.
- 10.2. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.
- 10.3. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан төлөөлөгчийн хаягаар илгээнэ.
- 10.4. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:
 - 10.4.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр төлбөр төлсөн баримтыг үндэслэн;
 - 10.4.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.
- 10.5. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.
- 10.6. ГЕН-ийн 10.5-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.
- 10.7. Нэн даруй мэдэгдэх шаардлагатай яаралтай мэдэгдлийг ГЕН-ийн 10.2-т зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг дараа нь баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.

Төлөөлөгч өөрчлөгдөх

- 10.8. Талууд төлөөлөгчийг өөрийн санаачилгаар өөрчилж болно.
- 10.9. Төлөөлөгч өөрчлөгдсөн тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.
- 10.10. Мэдэгдэлд төлөөлөгчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаягийг заавал тусгасан байна.
- 10.11. Төлөөлөгч өөрчлөгдсөн мэдэгдлийг нөгөө талд хүргүүлснээр өмнөх төлөөлөгчийн эрх, үүрэг дуусгавар болно.

Үйлчилгээнд өөрчлөлт, залруулга хийх нөхцөл

- 10.12. Талууд үйлчилгээний чанар, үр ашиг, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор ажлын ерөнхий гүйцэтгэлийн хүрээнд хамаарсан, техник технологийн хувьд боломжтой бөгөөд гэрээний хугацаа, үнэд нөлөөлөхгүй бол ажилд өөрчлөлт оруулж болно.
- 10.13. Гүйцэтгэгч болон Захиалагч өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрчлөлтийн төслийг гүйцэтгэгч гаргана.
- 10.14. Захиалагч төслийг үндэслэн ГЕН-ийн 10.12-т заасан нөхцөл, шаардлага хангасан гэж үзвэл өөрчлөлт хийх мэдэгдлийг хүргүүлнэ.
- 10.15. Захиалагчийн зөвшөөрөлгүй өөрчлөлт хийсэнтэй холбоотой техник, технологийн алдаа гарсан, гэрээний

- хугацаа хэтэрсэн, үнэ өссөн тохиолдолд үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.
- Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал**
- 10.16. Үйлчилгээг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Гүйцэтгэгч энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 10.7-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.
- 10.17. Гүйцэтгэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.
- 10.18. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцөж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.
- 10.19. Гэрээг хэрэгжүүлэх захиалагчийн зааварчилгаа, Гүйцэтгэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Гүйцэтгэгч ГЕН-ийн 4.5-д заасан хүсэлтийг гаргаж болно.
- Оюуны өмчийн эрх зөрчих**
- 10.20. Үйлчилгээг үзүүлэх явцад болон үйлчилгээ үзүүлсэнтэй холбоотойгоор гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.
- Алданги**
- 10.21. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Гүйцэтгэгчид төлнө.
- 10.22. Гүйцэтгэгч нь үйлчилгээг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.
- 10.23. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.
- 10.24. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийн хамт өгнө.
- Маргаан шийдвэрлэх**
- 10.25. Гэрээнээс үүссэн аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 10.26. Маргааныг зөвшилцөж, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

| | |
|------------|---|
| ГЕН 4.1. | <p>Үйлчилгээ үзүүлж эхлэх хугацаа: Өмнөх гэрээний хугацаа дууссан өдрөөс 1 жилийн хугацаанд буюу дараах байдлаар гэрээний хэрэгжих хугацаа үргэлжилнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • <i>Багц №1 Баруун бүс-2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс 2026 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийг дуустал,</i> • <i>Багц №2 Зүүн бүс - 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс 2026 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийг дуустал,</i> • <i>Багц №3 Урд бүс – 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал,</i> • <i>Багц №4 Хойд бүс - 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал.</i> <p><i>Төрийн банкны Аюулгүй байдлын газраас гаргасан хуваарийн дагуу Улаанбаатар хотод байрлах цэг /багц тус бүрт орсон нэгжийн жагсаалтын дагуу/-т үйлчилгээг үзүүлнэ.</i></p> |
| ГЕН 4.2. | <p>Үйлчилгээ үзүүлэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө) ирүүлэх хугацаа: Гэрээний дагуу дохиолол хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх хугацаа нь 24 цагаар байна.</p> |
| ГЕН 4.9. | <p>Үйлчилгээний явцын тайлан гаргах хуваарь болон ирүүлэх хугацаа: Тийм Дохиолол хамгаалалтын мэдээг сар бүрийн 05-ны өдрийн дотор ирүүлнэ.</p> |
| ГЕН 5.2. | <p>Үнийн тохируулга хийх аргачлал: Үнийн тохируулга хийхгүй.</p> |
| ГЕН 5.4. | <p>Урьдчилгаа төлбөр олгох эсэх: Үгүй</p> |
| ГЕН 5.5. | <p>Урьдчилгаа төлбөр олгох хугацаа: Үгүй</p> |
| ГЕН 5.6. | <p>Төлбөр төлөх хугацаа: Сар тутам.</p> <p><i>Үйлчилгээ үзүүлж эхэлсэн өдрөөс хойш Захиалагч нь нэхэмжлэлийн дагуу тухайн сарын үйлчилгээний төлбөрийг дараа сарын 25-ны өдрийн дотор хийнэ.</i></p> |
| ГЕН 6.1. | <p>Урьдчилгаа төлбөрийн хэмжээ: Үгүй</p> <p>Урьдчилгаа төлбөрийн баталгаа ирүүлэх хугацаа: Үгүй</p> |
| ГЕН 6.7. | <p>Чанарын баталгаа:</p> <p>Чанарын баталгаа шаардах эсэх: Шаардахгүй</p> <p><i>Чанарын баталгаа шаардах бол,</i></p> <p>Чанарын баталгааны хэмжээ:</p> |
| ГЕН 6.13. | <p>Үйлчилгээний баталгаат хугацаа: 12 сар</p> |
| ГЕН 7.5. | <p>Даатгал:</p> <p><i>Гүйцэтгэгч нь үйлчилгээ үзүүлэх үед гарч болох аливаа эрсдэлээс хамгаалж үйлчилгээний онцлог болон бусад нөхцөлүүдийг харгалзан Байгууллагын эрсдэлийн даатгалаар даатгуулна.</i></p> |
| ГЕН 10.22. | <p>Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь:</p> <p>Алдангийн хувь: Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээс хоног тутамд 0.5 хувь</p> |

ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.

Дугаар № *[Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]*

..... хот/аймаг

Нэг талаас *[захиалагчийн нэрийг бичих]* (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас *[гүйцэтгэгчийн нэрийг бичих]* (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд ажил гүйцэтгэх, дагалдах бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Үйлчилгээ” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх Үйлчилгээний үнэ нь *[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих]* төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Гүйцэтгэгч *[Гүйцэтгэгчийн нэрийг бичих]*-ийн харилцах *[Банкны нэрийг бичих]* банкны *[дансны дугаар бичих]* дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - 3.2. Гүйцэтгэгч тендер илгээсэн маягт;
 - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
 - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
 - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
 - 3.6. Урьдчилгаа төлбөрийн баталгаа;
 - 3.7. Техникийн тодорхойлолт;
 - 3.8. Үйлчилгээ үзүүлэх хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
 - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:
 - 4.2. Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: **2024 оны 08 дугаар сарын 20-ны өдөр**
Тендер шалгаруулалтын төрөл: **Үйлчилгээ**
Тендер шалгаруулалтын нэр: **Улаанбаатар хотын төв байрнууд болон нэгжүүдийн дохиолол хамгаалалт, суурилуулалтын үйлчилгээ үзүүлэх**
Тендер шалгаруулалтын дугаар: **ТБ/20240103211/01/01**
Нийт төсөвт өртөг: **232,980,000 (Хоёр зуун гучин хоёр сая есөн зуун наян мянган) төгрөг**
Тендер шалгаруулалтын арга: **Нээлттэй**

- Төрийн банк ХК** нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.
- Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: **Багцтай.**
 - Багц №1 Баруун бүс – 54,240,000 /тавин дөрвөн сая хоёр зуун дөчин мянган төгрөг**
 - Багц №2 Зүүн бүс – 62,160,000 /Жаран хоёр сая нэг зуун жаран мянган/ төгрөг**
 - Багц №3 Урд бүс – 56,820,000 /тавин зургаан сая найман зуун хорин мянган/ төгрөг**
 - Багц №4 Хойд бүс – 59,760,000 /Тавин есөн сая долоон зуун жаран мянган/ төгрөг**
- Тендерийг **2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 10 цаг 00 минут**-аас өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг **2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 10 цаг 10 минут-т** нээнэ.
- Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: **Зөвшөөрөхгүй**
- Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **Эрхгүй**
- Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.
- Тендерийн баталгаа шаардах эсэх: **Тийм**
Тендерийн баталгааны дүн: **1,694,900 /Хоёр сая нэг зуун ерэн зургаан мянга гурван зуун далан төгрөг/**
 - Багц №1 Баруун бүс - 271,200 төгрөг**
 - Багц №2 Зүүн бүс – 310,800 төгрөг**
 - Багц №3 Урд бүс – 284,100 төгрөг**
 - Багц №4 Хойд бүс – 298,800 төгрөг**
- Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: **Үгүй**
- Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: **Үгүй**
- Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

Төрийн банк

**Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Холбоочдын гудамж,
Төрийн банкны төв 2 дугаар байр, 2 дугаар давхар, 202 тоот өрөө.**